



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 06 өдөр

Дугаар А/337

Алтай хот

Төр, захиргааны байгууллагуудын  
ажлын цагийн хуваарьт зохицуулалт  
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалт, 60 дугаар зүйлийн 60.1.14, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймаг, орон нутгийн онцлогийг харгалзан, хаврын тариалалт, намрын ургац хураалт, өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангахад албан хаагчдын оролцоог бүрдүүлж, ажлын цаг ашиглалтыг сайжруулах зорилгоор аймгийн хэмжээнд төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийг 2022 оны 06 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 07-ны өдөр хүртэлх хугацаанд эхлэх цагийг 08:30 цагт, тарах цагийг 17:30 цагт, цайны цагийг 12:30 цагаас 13:30 цаг байхаар өөрчилсүгэй.

2.Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд мэдээллэж, сурталчилан таниулах ажлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (П.Хулан)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын удирдлагуудад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ц.Батзориг)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

